



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №22



2018 оны 6-р сарын 18-22-ны хооронд

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй байж болзошгүй нийт **949** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 65(6.8%) галзуугийн эрсдэлд өртсөн, 875(92.2%) хачигт халдвар, 2(0.2%) бэтэг, 1(0.1%) хумхаа, 6(0.6%)-ийг боомын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 875 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18.7%-иар, эпидемиологийн 24-р долоо хоногийн үзүүлэлттэй харьцуулахад 15 тохиолдлоор илүү байна.



6 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар хачигт риккетсиоз 91(10.4%), хачигт боррелиозын 16(1.8%), хачигт энцефалит 8(0.9%) тохиолдол тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдаж, 89 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 65 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 35%-иар буурсан. Эпидемиологийн 24-р долоо хоногт 4 эрсдэлт өртсөн тохиолдол бүртгэгдсэн байна.



1.3 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол:

Ховд, Төв, Дорнод аймгийн 4 суманд боомын арьсны хэлбэрийн хүний өвчлөлийн сэжигтэй 6 тохиолдол бүртгэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр тохиолдол үгүйсгэгдсэн байна.

1.4 Бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Увс аймгийн Улаангом сум, нийслэлийн ХУД-ээс бэтэг өвчний онош тодруулахаар 2 хүний шинжилгээний материал ЗӨСҮТ-ийн лабораторит хүлээн аваад байна.

1.5 Хумхаа өвчний сэжигтэй тохиолдол:

Канад улсын иргэн. Өвчтөн “D” 34 настай, эмэгтэй. 2018 оны 3 дугаар сарын 16-29-ний хооронд Индонез улсад зорчих үедээ шумууланд хазуулсан өгүүлэмжтэй. 3 дугаар сарын 31-ний өдөр толгой өвдөх, дотор муухайрах, бүх бие янгинах, гүйлгэх шинж тэмдэг илэрч, Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний өдөр хэвтсэн.

Хариу арга хэмжээ:

- Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний 14 цагийн орчимд ЗӨСҮТ-ийн дуудлагын баг газар дээр нь очиж ажилласан.
- Өвчтнийг тусгаарлаж, хумхаа өвчний онош тодруулахаар сорьц дээжилж, ЗӨСҮТ-ийн лабораторид нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн шинжилгээгээр цусанд хумхаа өвчний үүсгэгчийн ДНХ тодорхойлогдоогүй онош үгүйсгэгдсэн.

1.5 Мэрэгч амьтны дуудлага:

2018 оны гарсаар нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, *БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ийн хэмжээнд нийт 23 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Тайлбар (*2 удаагийн амьтны дуудлаганд үйлчилсэн)

6 дугаар сарын 20-21-ны хооронд БГД-ийн хэмжээнд 2 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжилгээ хийхээр хүлээн авав.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны галзуу өвчин:

Увс аймгийн Өндөрхангай сумын Цагаан-Нуур багт 6 дугаар сарын 04-ны өдөр малчин айлын 1 үхэрт мал, амьтны галзуу өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч Аймгийн МЭАЦЛ-ийн шинжилгээний дүнгээр галзуу өвчнөөр өвчилсөн болох тогтоогдсон байна.

Авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ:

- Тус суманд 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон
- Голомтот нутгийн 2 багийн 120 хүнд галзуу өвчнөөс сэргийлэх сургалт, сурталчилгаа хийсэн.
- Галзуугийн эрсдэлд өртсөн тохиолдол бүртгэгдээгүй
- Голомтот нутгийн 2 өрхийн 3000 малыг вакцинжуулсан.

Эх сурвалж: Увс ЗӨСТ

Мал, амьтны галзуу өвчин:

Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын 5-р багийн “Харгана” гэдэг газар 6 дугаар сарын 20-нд малчин айлын 1 үхэрт мал амьтны галзуу өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч Аймгийн МЭАЦЛ-ийн шинжилгээний дүнгээр галзуу өвчнөөр өвчилсөн болох тогтоогдсон байна.

Авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ:

- Тус суманд 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон
- Голомтот нутгийн 1 өрхийн 6 хүнд үзлэг хийж, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа хийсэн.

Эх сурвалж: Өвөрхангай ЗӨСТ

Олон улсад:

Шүлхий өвчин:

БНХАУ-ын Хубэй мужийн малын захад “О” хэвшлээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдэж, 3 үхэр өвчилж үхэн, 33 үхрийг устгасан байна. Тус газарт хязгаарлалтын дэглэм тогтоож, хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шүлхий өвчин:

Мозамбик улсын Тэтэ хотын Моатизе мужийн үхрийн аж ахуйд шүлхий өвчин бүртгэгдэж, 290 үхэр өрөмхий байснаас, 48 үхэр өвчилж, 8 үхрийг устгасан. Тус газарт хязгаарлалтын дэглэм тогтоож, тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ


Африкийн гахайн халуурал өвчин:

Латви улсын Лимбазу мужийн ойд 1 зэрлэг гахай өвчилж үхсэн байна. Тус газарт тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин:

ОХУ-ын Пензенская областад өндөр хоруу чанартай шувууны томуу бүртгэгдэж, 24 шувуу өртөмхий байснаас, 14 шувуу өвчилж үхэн, 10 шувууг устгасан байна. Тус газарт хязгаарлалтын дэглэм тогтоож, тандалтын хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажилласан байна.




Эх сурвалж: ДАЭМБ

Эбола вируст халдвар:

6 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын Экватор мужийн эрүүл мэндийн бүсээс Эбола вируст халдварын 60 тохиолдол, 28 нас баралт, 38 батлагдсан тохиолдол мэдээлэгдсэн. 41 насанд өндөр, эрэгтэйчүүд зонхилон өвчилсөн байна. *Хариу арга хэмжээ:*

- Идвэхтэй тандалт үргэлжилж байна
- 5-р сарын 21-нээс, 6-р сарын 17-ны хооронд Вангата 834, Ибоко 1434, Викоро 779, Киншаса 13, Ингэйдэ 77 хүн тус тус дархлаажуулалтанд хамрагдсан байна.



Зураг 1. ЭВХ-ын тархалт

Эх сурвалж: ДЭМБ

Жич: Энэ долоо хоногт Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн.

Салбар төвүүд ШУН-ийн eop@nczd.gov.mn мэдээгээ ирүүлж байна уу?